

## Журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.7, 49 дүгээр зүйлийн 49.1.4, 49.3 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.16 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Гишүүнчлэлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэн баталсан журмыг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Шинэчлэн баталсан “Гишүүнчлэлийн журам”-ыг шинэчлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Энэхүү журмыг Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлагдсанаар компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 тоот тогтоолоор баталсан журмыг хүчингүйд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.БАТХУЯГ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн  
2018/07 тоот тогтоолын хавсралт



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН  
“ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ”

## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### ХОЁР. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Гишүүнээр элсэх өргөдөл гаргагчийн ерөнхий шаардлага
- 2.2. Брокерийн компанид тавигдах шаардлага
- 2.3. Дилерийн компанид тавигдах шаардлага

#### ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ТАТГАЛЗАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ

- 3.1. Гишүүнээр элсэх өргөдөл гаргах
- 3.2. Гишүүнээр элсүүлэх, элсүүлэхээс татгалзах тухай шийдвэр гаргах
- 3.3. Гишүүний үзүүлэх үйлчилгээний хөлс

#### ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Биржийн эрх
- 4.2. Биржийн үүрэг
- 4.3. Гишүүний эрх
- 4.4. Гишүүний үүрэг

#### ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1.1. Сануулах арга хэмжээ авах
- 5.1.2. Торгууль ноогдуулах, алданги тооцох арга хэмжээ авах
- 5.1.3. Гишүүний үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах
- 5.1.4. Гишүүний эрхийг түтгэлзүүлэх
- 5.1.5. Гишүүнээс хасах

#### ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

#### ХАВСРАЛТ

Гишүүнчлэлийн гэрээ

Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч компанийн өргөдлийн маягт

Техник, тоног төхөөрөмжийн шаардлага

Гишүүнд үзүүлэх үйлчилгээний хөлс

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/ “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 70 дугаар зүйлийн дагуу үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд биржид гишүүнээр элсэхээр гаргасан өргөдлийг хүлээн авах, гишүүнээр элсүүлэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, сэргээх, хасах болон гишүүнд тавих хяналт түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гишүүн үнэт цаасны компани /цаашид “Гишүүн” гэх/ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/, Биржээс батлан гаргасан дүрэм, журам, заавар болон холбогдох бусад хууль тогтоомж, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 1.3 Бирж нь гишүүнээр элсэхээр өргөдөл гаргасан этгээдийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, гишүүнд арилжаанд оролцохтой холбогдох үйлчилгээг үзүүлэх, хяналт тавих, хариуцлага ногдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй, үл ялгаварлах зарчмыг баримтална.

### ХОЁР. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 Гишүүнээр элсэх өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна:
  - 2.1.1 Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх. Энэхүү зөвшөөрлийг авахдаа тухайн брокер, дилерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх Биржээс гаргасан дүгнэлтэд үндэслэсэн байвал зохино.
  - 2.1.2 Өөр арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл авсан нь биржийн гишүүнээр элсэх үндэслэл болохгүй бөгөөд биржийн шаардлагыг заавал хангах;
  - 2.1.3 Үйл ажиллагаагаа тогтвортой, тасралтгүй явуулах дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй байх;
  - 2.1.4 Өөрийн хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон хэмжээг хангаж байх;
  - 2.1.5 Энэхүү журмын 2.1.3-д заасан хөрөнгийн хэмжээний гурваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдлээс хамгаалах сан байгуулсан байх;
  - 2.1.6 Энэхүү журмын Хавсралт 4-т заасан үйлчилгээний хөлсийг төлсөн байх;
  - 2.1.7 Хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомжтой бүрэн танилцсан, тэдгээр хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхийг баталсан баталгааг компанийг төлөөлж Хавсралт 2-ийн НЭГ-д заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтан, хавсралт 2-ийн ХОЁР.А-д заасны дагуу боловсон хүчин тус бүрээр гаргасан байх;
  - 2.1.8 Харилцагчдын үнэт цаасны бүртгэл тооцоо, арилжаа, төлбөр тооцооны мэдээллийг түргэн, шуурхай боловсруулж гаргах програм хангамжтай байх
  - 2.1.9 Энэхүү журмын Хавсралт 3-т заасан шаардлагуудад нийцсэн ажлын байр, техник, тоног төхөөрөмжөөр хангагдаж, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байх;

- 2.1.10 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26.1-т заасан Зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм, журмыг дагаж мөрдөх.
- 2.1.11 Зохицуулалттай этгээдийн үнэт цаасны арилжаанд оролцох мэргэжилтэн нь МХБ ТӨХК-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын дагуу эрх авсан байх.
- 2.2 Брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд энэхүү журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл шаардлагыг хангасан байна.
  - 2.2.1 Хорооны Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журмын 3.2.1-д заасан мэргэжлийн боловсон хүчний шаардлагыг хангасан байх;
  - 2.2.2 Дараах журмуудыг боловсруулсан байна:
    - 2.2.2.1 Брокерийн үйл ажиллагааны журам;
    - 2.2.2.2 Дотоод хяналтын үйл ажиллагааны тухай журам;
    - 2.2.2.3 Харилцагчдыг эрсдлээс хамгаалах үйл ажиллагааны журам;
    - 2.2.2.4 Харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл түгээх үйл ажиллагааны журам;
    - 2.2.2.5 Зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журам.
- 2.3 Дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь энэхүү журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл шаардлагыг хангасан байх:
  - 2.3.1 Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журмын 3.3.1-т заасан мэргэжлийн боловсон хүчинтэй байх;
  - 2.3.2 Дараах журмуудыг боловсруулсан байна:
    - 2.3.2.1 Дилерийн үйл ажиллагааны журам;
    - 2.3.2.2 Дотоод хяналтын үйл ажиллагааны тухай журам.

ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ТАТГАЛЗАХ ТУХАЙ  
ШИЙДВЭР ГАРГАХ

- 3.1 Гишүүнээр элсэх өргөдөл гаргах
  - 3.1.1 Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч нь энэхүү журмын Хавсралт 2-т заасан өргөдлийн маягтыг бөглөж, холбогдох бичиг баримтуудыг хавсарган ирүүлнэ;
  - 3.1.2 Бирж нь холбогдох хууль, дүрэм, журамд заасан шаардлагуудыг үнэн зөв, бүрэн хангасан бичиг баримтыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ;
  - 3.1.3 Нэмэлт материал, тодруулга ирүүлэх шаардлагатай тохиолдолд энэхүү журмын 3.1.2-д заасан хугацааг нэг удаа ажлын 10 өдөр хүртэл хугацаагаар сунгаж болно;
  - 3.1.4 Өргөдөл гаргагч нь өргөдлийн албан баримт бичгийг “Монгол улсын стандарт –MNS 5140-1,2,3:2011”-ийн дагуу боловсруулан, эмхлэн товъёоглож, Гүйцэтгэх захирлын гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан байна;
  - 3.1.5 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гишүүнээр бүртгүүлэхдээ холбогдох бичиг баримтуудыг Монгол хэл дээр үйлдэн баталгаажуулж ирүүлнэ;
  - 3.1.6 Өргөдлийг хүлээн авч хянах явцад ирүүлсэн бичиг баримтад нэмэлт өөрчлөлт орсон бол өргөдөл гаргагч нь энэ тухайгаа ажлын 3 өдрийн дотор Биржид мэдэгдэнэ;
- 3.2 Гишүүнээр элсүүлэх, элсүүлэхээс татгалзах тухай шийдвэр гаргах
  - 3.2.1 Дараах тохиолдолд Биржийн гишүүнээр элссэнд тооцно:

- 3.2.1.1 Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгжийн дүгнэлтийг үндэслэн гишүүнээр элсүүлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан;
- 3.2.1.2 Гишүүнээр элсүүлэх тухай Биржийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу өргөдөл гаргагч нь Гишүүнчлэлийн гэрээг Биржтэй байгуулсан.
- 3.2.2 Дараах тохиолдолд Биржийн гишүүнээр элсүүлэхээс татгалзана:
  - 3.2.2.1 Бичиг баримтын зөрчилтэй, худал, төөрөгдүүлсэн, алдаатай эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл агуулсан, Биржээс өргөдөлтэй холбогдуулан шаардсан мэдээллийг бүрэн ирүүлээгүй;
  - 3.2.2.2 Хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-д заасан нөхцөл шаардлагыг хангаагүй;
  - 3.2.2.3 Гишүүнээс хасагдсан компани нь дахин гишүүнээр элсэх тухай өргөдлийг 6 сарын дотор Биржид гаргасан;
  - 3.2.2.4 Өргөдөл гаргагч гишүүнээр элсэж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нь түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компанийн үйл ажиллагаатай харшилж, сонирхлын зөрчил үүсгэнэ гэж үзсэн.
  - 3.2.2.5 Өргөдөл гаргагч нь биржийн гишүүнээр элсэх хүсэлт гаргасан өдрөөс хойш бичиг баримтаа шаардлага хангахуйц түвшинд бүрдүүлээгүй 6 сарын хугацаа хэтэрсэн;
  - 3.2.2.6 Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн гэх үндэслэлээр гишүүнээр элсүүлэхээс татгалзсан компани нь 1 жилийн дотор дахин гишүүнээр элсэх хүсэлт гаргасан;
- 3.2.3 Биржийн Гүйцэтгэх захирал нь гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэрийг тайлбарын хамт өргөдөл гаргагч этгээдэд бичгээр хүргүүлнэ.

### 3.3 Гишүүнд үзүүлэх үйлчилгээний хөлс, хөнгөлөлт

- 3.3.1 Гишүүнд үзүүлэх үйлчилгээний хөлсийг Хавсралт 4-т заасны дагуу төлнө;
- 3.3.2 Гишүүн нь Бирж дээр хийгдсэн тухайн жилийн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн бол дараа жилийн гишүүнчлэлийн жилийн үйлчилгээний хөлсөөс 10 хүртэлх хувиар хөнгөлж болно;
- 3.3.3 Гишүүн нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн бол жилийн үйлчилгээний хөлсөөс 10 хувиар хөнгөлнө.
- 3.3.4 Биржид гишүүнээр элсүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш Гишүүн нь гишүүний жилийн үйлчилгээний хөлсөөс нэг жилийн хугацаанд чөлөөлөгдөнө;
- 3.3.5 Гишүүний эрхийг түр хязгаарласан болон түдгэлзүүлсэн нь гишүүнчлэлийн хөлс төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй;
- 3.3.6 Гишүүнээс хасагдсан тохиолдолд гишүүнчлэлийн элсэлтийн болон жилийн хөлсийг буцаан олгохгүй.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

### 4.1 Бирж дараах эрх эдэлнэ:

- 4.1.1 Гишүүний үйл ажиллагаанд хяналт шалгалт тавьж, журам заавар гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, холбогдох хариуцлага ногдуулах;

- 4.1.2 Энэхүү журам болон “Гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан үйлчилгээний хөлс, холбогдох бусад төлбөрийг тогтоосон хугацаанд төлүүлэхийг шаардах;
  - 4.1.3 Гишүүний санхүүгийн тайлан мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
  - 4.1.4 Гишүүн нь баримт материал хуурамчаар бүрдүүлсэн байж болзошгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх, шалгуулах хүсэлт гаргах;
  - 4.1.5 Гишүүний гаргасан зөрчил нь хөрөнгө оруулагч харилцагчдад их хэмжээгээр хохирол учруулсан бөгөөд хохирлоо барагдуулаагүй, мөн гэмт хэргийн шинжтэй бол холбогдох материалыг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
  - 4.1.6 Гишүүдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэхдээ Биржийн “Мэдээллийн журам”-ыг баримтлах.
  - 4.1.7 Гишүүдийн хууль тогтоомжоор болон “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргийн биелэлтийг шударга дүгнэх, дүнг албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх.
- 4.2 Бирж дараах үүрэг хүлээнэ:
- 4.2.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржээс баталсан журмын дагуу өдөр тутмын арилжааг зохион байгуулах, арилжааны программын хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн нууцлалыг хадгалах;
  - 4.2.2 Гишүүдийн үйл ажиллагаатай холбогдох шаардлагатай мэдээ, материалыг цаг тухайд нь холбогдох журмын дагуу гаргаж өгөх;
- 4.3 Гишүүн нь дараах эрх эдэлнэ.
- 4.3.1 Үнэт цаасны арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүй гаргуулан авах;
  - 4.3.2 Үнэт цаасны зах зээл, Бирж, Гишүүдийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргах, хамтран ажиллах;
  - 4.3.3 Биржийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах;
  - 4.3.4 Биржид санал хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах, асуудлыг хамтран шийдвэрлэх, харилцан зөвшилцөх;
  - 4.3.5 Үнэт цаасны арилжаанд алсаас оролцох хүсэлтээ Биржид гаргаж шийдвэрлүүлэх;
  - 4.3.6 Биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд Хороонд гомдол гаргах;
- 4.4 Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ:
- 4.4.1 Биржийн гишүүн байх хугацаандаа энэхүү журмын 2 дугаар зүйл болон “Гишүүнчлэлийн гэрээ”-д заасан шаардлагуудыг биелүүлж ажиллах;
  - 4.4.2 Энэхүү журам болон “Гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан үйлчилгээний хөлс болон холбогдох бусад төлбөрийг цаг тухайд нь тогтмол төлөх;
  - 4.4.3 Гишүүн нь энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахад гарсан аливаа өөрчлөлтүүд болон гэрээнд заасан мэдээ, мэдээллийг Биржид тогтоосон хугацаанд ирүүлэх;
  - 4.4.4 Энэ журмын 4.3.5-д заасны дагуу алсаас арилжаанд оролцох тохиолдолд “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г Биржтэй байгуулах;
  - 4.4.5 Гишүүн нь мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах;
  - 4.4.6 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж, аудитын дүгнэлтийн хамт дараа оны 3 дугаар

- сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор Биржид тус тус ирүүлэх;
- 4.4.7 Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;
- 4.4.8 Гишүүн нь өөрийн компанийн албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж дараах мэдээ мэдээллийг өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлнэ:
- 4.4.8.1 Сар бүрийн үнэт цаасны арилжааны тайлан мэдээ;
- 4.4.8.2 Жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан;
- 4.4.8.3 Өөрийн компанийн дүрэм, журамд орсон өөрчлөлтүүд;
- 4.4.8.4 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;
- 4.4.8.5 Компанийн хаяг, байршил түүнд орсон өөрчлөлт;
- 4.4.8.6 Хууль, дүрэм журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилт;
- 4.4.9 Хорооны тогтоолын дагуу гишүүний тусгай зөвшөөрөл хүчингүй болсноор Гишүүний эрх цуцлагдсан тохиолдолд Гишүүн нь Хорооны тогтоолын дагуу холбогдох баримтуудыг заасан хугацаанд Биржид хүлээлгэн өгнө.

## ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1 Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд хяналт шалгалтын журамд заасан үндэслэл, чиглэлийн дагуу Гишүүний үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.2 Бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо, Бирж болон Монголын арилжаа эрхлэгчдийн холбооноос гаргасан дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих ба Гишүүний үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлын төрлөөс шалтгаалан Гишүүнд дараах арга хэмжээг авна.
- 5.2.1 Дараах тохиолдолд сануулах арга хэмжээ авна:
- 5.2.1.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо, Бирж болон Монголын арилжаа эрхлэгчдийн холбооноос гаргасан дүрэм, журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаандаа биелүүлээгүй;
- 5.2.1.2 Энэхүү журмын 4.4 дэх заалтуудыг биелүүлээгүй.
- 5.2.2 Дараах тохиолдолд “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4.2.2, 4.2.3 дүгээр зүйлд заасны дагуу торгуулийн арга хэмжээг авна:
- 5.2.2.1 Энэхүү журмын 5.2.1-дэх заалтуудыг 2 болон түүнээс дээш удаа зөрчсөн;
- 5.2.2.2 Сануулах арга хэмжээний хүрээнд Биржээс өгсөн үүрэг, даалгаврыг заасан хугацаанд биелүүлээгүй.
- 5.2.3 Дараах тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээ авна:
- 5.2.3.1 Хороо болон Хорооны Улсын байцаагчийн шийдвэрээр;
- 5.2.3.2 Энэхүү журмын 3.3.1 дугаар зүйл болон Хамтран ажиллах гэрээнд заасан аливаа төлбөр, хөлсийг хугацаанд нь төлж барагдуулалгүй 30 хоног болсон;
- 5.2.3.3 Арилжааны дэнчин байршуулах эсхүл төлбөр гүйцэтгэх үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тухай арилжааны төлбөр, тооцооны байгууллагаас мэдэгдсэн;
- 5.2.3.4 Арилжааны төлбөр тооцооны байгууллагын гишүүнчлэлээс хасагдсан;



- 5.2.3.5 Гишүүний ажилтан нь үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй “Ёс зүйн дүрэм”-ийг удаа дараа зөрчсөн.
- 5.2.4 Дараах тохиолдолд гишүүний эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна:
  - 5.2.4.1 Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарласан арга хэмжээтэй холбогдуулан Биржээс өгсөн үүргийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй;
  - 5.2.4.2 Олон нийтийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, хуурамч мэдээлэл тараасан;
  - 5.2.4.3 Зах зээлийг урвуулан ашиглах журмыг зөрчиж аливаа байдлаар хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон, хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэл гаргасан;
  - 5.2.4.4 Сүүлийн 6 сарын хугацаанд “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.1, 37.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа явуулаагүй, эсхүл 6 сар үнэт цаасны арилжаанд оролцоогүй.
- 5.2.5 Дараах тохиолдолд гишүүнээс хасна:
  - 5.2.5.1 Гишүүнээс хасагдах хүсэлтээ өөрөө гаргаж болно. Энэ тохиолдолд Гишүүн нь Биржээс тавих нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан байна;
  - 5.2.5.2 Гишүүний эрхийг түдгэлзүүлснээс хойш 3 сарын хугацаанд эрхээ сэргээлгэх талаар арга хэмжээ аваагүй;
  - 5.2.5.3 Хорооноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;
  - 5.2.5.4 Гишүүний төлбөрийн чадвар нь алдагдсан, эсхүл төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон, түүнийг татан буулгах ажиллагаа эхэлсэн, дампуурсан буюу эрх хүлээн авагч томилогдсон зэрэг тохиолдолд Хороо, шүүх, хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу;
  - 5.2.5.5 Биржийн “Хяналт шалгалтын журам”-ын дагуу Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгжээс гишүүний эрхийг цуцлах тухай санал, дүгнэлт гаргасан;
  - 5.2.5.6 Энэ журмын 3.3.1 дугаар зүйл болон “Гишүүнчлэлийн гэрээ”- д заасан аливаа төлбөр, хураамж, хөлсийг тогтоосон хугацаанд төлж барагдуулалгүй 6 сар болсон;
  - 5.2.5.7 Биржийн үнэт цаасны арилжаа, гишүүнчлэл, хяналтын журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;
  - 5.2.5.8 Биржийн болон дотоодын хөрөнгийн зах зээлийн нэр хүндэд харшлах үйл ажиллагаа, үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
  - 5.2.5.9 Гишүүнээр элсэхдээ хуурамч баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
  - 5.2.5.10 Хууль, дүрэм, журам, гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актанд заасан бусад үндэслэл.
- 5.3 Дараах тохиолдолд гишүүний эрхийг сэргээнэ:
  - 5.3.1 Гишүүн гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдсэн, эсхүл Биржээс уг зөрчлийг арилсан гэж тогтоосон;
  - 5.3.2 Хорооноос гишүүний тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
  - 5.3.3 Зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх хяналтын байгууллагаас гишүүнд авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж үзсэн;
  - 5.3.4 Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.
- 5.4 Энэ журмын 5.2-т заасан хариуцлагын арга хэмжээ авах эсэхийг хариуцсан нэгжийн саналыг үндэслэн Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

5.5 Бирж нь Гишүүний эрхийг түдгэлзүүлсэн, гишүүнээс хасах тохиолдолд Хороо, арилжааны төлбөр, тооцооны байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон гишүүнд холбогдох шийдвэрийг нэн даруй мэдэгдэнэ.

#### ЗУРГАА. БУСАД

6.1 Энэхүү журмыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тэдгээрийн хүчин төгөлдөр болох хугацаа, дагаж мөрдөх журмын талаарх Биржийн ТУЗ-ийн шийдвэрийг Хороо батламжилснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гишүүн нь Биржээс гаргасан шийдвэр хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тус шийдвэртэй холбоотой гомдлыг Хороонд гаргана.

-----oOo-----

Батлав. “Монголын хөрөнгийн бирж”  
ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

Батлав. “.....” ХХК-  
ийн Гүйцэтгэх захирал

.....

.....

## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ

201... оны ... сарын... -ны өдөр  
хот

№...

Улаанбаатар

Нэг талаас “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/, түүнийг төлөөлөн  
....., нөгөө талаас Биржийн гишүүн үнэт цаасны компани  
“.....” ХХК /цаашид “гишүүн”, хамтад нь “талууд” гэх/ нар дараах  
нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг нэг жилийн хугацаатай байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь үнэт цаасны компанийг гишүүнээр элсүүлж, үнэт цаасны зах зээлд арилжаа явуулах нөхцөл, дэд бүтцээр хангах, Гишүүн нь харилцан тохиролцсон гишүүнчлэлийн төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2. Талууд үйл ажиллагаандаа Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржээс баталсан журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.

1.3. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.

1.4. Талууд хамтран ажиллахдаа бизнесийн болон ажил хэргийн нэр хүндийг гуравдагч этгээдийн өмнө харилцан хамгаалж, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэнэ.

1.5. Гишүүн байгууллага нь гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага, үйл ажиллагаа явуулахад тавигдах нөхцөл шаардлагыг хангаж байгаа гэх баталгаа гаргаж байгаа бөгөөд уг баталгааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг бие даан хариуцна.

## ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Бирж дараах эрх эдэлнэ:

2.1.1. “Гишүүнчлэлийн журам” болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээний хөлс болон холбогдох бусад төлбөрийг цаг тухайд нь төлүүлэх, тогтоосон хугацаанд төлөөгүй нөхцөлд “Гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу хариуцлага ногдуулах;

2.1.2. Гишүүний хууль, дүрэм журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Биржээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;

2.1.3. Гишүүний санхүүгийн тайлан мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;

- 2.1.4. Гишүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, өргөдөл гомдлын дагуу болон журам заавар, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, Биржийн “Хяналт шалгалтын журам”, “Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх заавар” болон бусад холбогдох журам, гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулах, тус саналыг Хороонд хүргүүлэх;
  - 2.1.5. Гишүүний гаргасан зөрчил нь хөрөнгө оруулагч, харилцагчдад их хэмжээгээр хохирол учруулсан бөгөөд хохирлоо барагдуулаагүй, мөн гэмт хэргийн шинжтэй бол холбогдох материалыг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад шилжүүлэх.
- 2.2. Биржийн хүлээх үүрэг:
- 2.2.1. Өдөр тутмын арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн холбогдох журмын дагуу зохион байгуулах, арилжааны программын хэвийн ажиллагааг хангах;
  - 2.2.2. Гишүүний гаргасан хүсэлтийн дагуу түүний техник хангамж, программ хангамжийг Биржийн сүлжээнд анх холбоход шаардлагатай техникийн болон үйл ажиллагааны туслалцааг үнэ төлбөргүйгээр үзүүлэх, арилжааны системийг ашиглах заавар, зөвлөгөө өгөх;
  - 2.2.3. Харилцагч болон гишүүнээс ирүүлсэн санал, хүсэлтэд холбогдох алба, нэгж нь утсаар болон бусад арга, хэрэгслээр хариу өгөх;
  - 2.2.4. Гишүүнийг арилжаанд оролцох, мэдээлэл авах ижил нөхцлөөр хангах.
- 2.3. Гишүүн нь дараах эрх эдэлнэ:
- 2.3.1. Үнэт цаасны арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүй гаргуулан авах;
  - 2.3.2. Үнэт цаасны зах зээл, Бирж, Гишүүний үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргах, Биржтэй хамтран ажиллах;
  - 2.3.3. Биржийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах;
  - 2.3.4. Биржид санал хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх;
  - 2.3.5. Биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд Хороонд гомдол гаргах.
- 2.4. Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ:
- 2.4.1. Арилжааны системд Биржийн “Гишүүнчлэлийн журам”-д заасан шаардлага хангасан техник хэрэгсэл ашиглах ба Арилжааны системд нэвтрэх код, программ хангамжийн тохиргоо, түүний нууцлал, хамгаалалтыг хангаж, зориулалтын дагуу ашиглах, үүнтэй холбоотойгоор гарах аливаа зардлыг хариуцах;
  - 2.4.2. Гишүүний үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь Биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх авсан байх;
  - 2.4.3. “Гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу дараах үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлнө:
    - 2.4.3.1. Гишүүнчлэлийн хөлсийг улирал бүрийн эхний 10 хоногийн дотор;
    - 2.4.3.2. Арилжааны системд нэвтрэх эрхийн төлбөрийг улирал бүрийн эхний 10 хоногийн дотор;
    - 2.4.3.3. Арилжааны танхимаас Биржийн телефон утас ашиглан арилжаа хийсэн тохиолдолд утасны төлбөрийг дараа сарын 20-ны дотор;
    - 2.4.3.4. Торгууль, алдангийг тогтоосон хугацаанд багтаан төлөх.
  - 2.4.4. Гишүүний ажлын байрны байршил, хаяг тодорхой байх, олон нийтэд тодорхой бус нөхцөлд ойролцоо гарц гармын дагуу тэмдэг тавих, шилжилт хөдөлгөөнийг

тухай бүр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, харилцагчдыг хүлээн авах цагийн хуваарь гарган тогтмол мөрдөж ажиллах;

2.4.5. Тухайн жилийн арилжааны төлөвлөгөөг 1 дүгээр сарын 25-ны дотор Биржид ирүүлж, биелэлтийг хангаж ажиллах;

2.4.6. Биржид дараах мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлнэ:

2.4.6.1. Жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бэлтгэж, жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт дараа оны 3 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор Биржид тус тус ирүүлэх;

2.4.6.2. Компанийн дүрэм, журамд орсон өөрчлөлтийг ажлын 10 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;

2.4.6.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчний талаарх мэдээлэл түүнд орсон өөрчлөлтийг ажлын 10 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;

2.4.6.4. Компанийн хаяг, байршил түүнд орсон өөрчлөлтийг ажлын 3 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;

2.4.6.5 Харилцагчдаас авах арилжааны шимтгэлийн хувь хэмжээ /бүтээгдэхүүн тус бүрээр/

2.4.7. Холбогдох журмын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, түүний үнэн зөвийг хариуцах, харилцагчийн утсаар өгсөн захиалгыг дуу хоолойны болон дүрст бичлэгээр баталгаажуулж, бичлэгийг компьютерийн санамжид файл хэлбэрээр хадгалах, цахим хэлбэрээр ирүүлсэн захиалгыг захиалгын гэрээнд хавсаргах, цахим хэлбэрээр захиалга авах тусгай програм хэрэглэх, хяналт шалгалтын ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд анхан шатны баримт, холбогдох бусад баримт мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;

2.4.8 Гишүүн нь өөрийн цахим хуудастай байж харилцагчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллах;

## ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБОО

3.1. Бирж нь Гишүүнд мэдээллийг Биржийн цахим хуудас эсвэл цахим шуудангаар болон албан бичгээр хүргүүлж болно.

3.2. Гишүүн нь Биржид хүргүүлэх аливаа мэдээллийг бичгээр хүргүүлнэ.

3.3. Энэхүү гэрээний 3.1-д заасны дагуу Биржээс мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн тохиолдолд ажлын 3 өдөрт, цахим шуудангаар илгээсэн болон цахим хуудаст нийтэлсэн тохиолдолд тухайн өдөр гишүүнийг танилцсанд тооцно.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

4.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцан барагдуулна.

4.2. Гишүүн нь гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд гишүүнд дараах арга хэмжээг авч, үүргийн биелэлтийг хангуулна:

4.2.1. Бичгээр албан шаардлага хүргүүлэх /сануулах арга хэмжээнд тооцогдоно/;

- 4.2.2. Гэрээний 2.4.3.1, 2.4.3.2, 4.2.3-т заасан гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд Иргэний хуулийн 232.6-д заасныг үндэслэн хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги төлөх;
- 4.2.3. Бирж нь Гишүүнээс дараах төрлийн торгуулийг /хариуцлага хүлээлгэх/ Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэх эрхтэй:
- а/ Үнэт цаасны арилжаатай холбоотой анхан шатны баримт дутуу, буруу хөтөлсөн бол 50 000 /тавин мянга/ төгрөг, хэрэв зөрчлийг давтан гаргасан тохиолдолд 100 000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тус тус торгох;
  - б/ Гишүүнчлэлийн гэрээний 2.4.6 дахь заалт болон Биржээс өгсөн үүрэг, даалгаврыг хугацаандаа биелүүлээгүй нөхцөлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
  - в/ Харилцагчийн захиалгыг арилжааны программд оруулахад анхаарал болгоомжгүйн улмаас удаа дараа алдаа гаргасан, арилжааны дэгийг удаа дараа зөрчсөн, арилжааны программыг зохисгүйгээр ашигласан, нууцлалыг алдагдуулсан бол 500 000 /таван зуун мянга/ төгрөг, хэрэв зөрчлийг давтан гаргасан тохиолдолд 1 000 000 /нэг сая/ төгрөгөөр торгох;
  - г/ Биржийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд 500 000 /таван зуун мянга/ төгрөгөөр торгох;
  - д/ Харилцагчтай гэрээ байгуулаагүй, харилцагчийн мөнгөн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлаагүй бол 500 000 /таван зуун мянга/ төгрөг, хэрэв зөрчлийг давтан гаргасан тохиолдолд 1 000 000 /нэг сая/ төгрөгөөр торгох;
- 4.2.4. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах;
- 4.2.5. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх;
- 4.2.6. Гишүүнээс хасах.

4.3. Гишүүн нь ногдуулсан торгуулийг ажлын 10 өдөрт багтаан төлөөгүй тохиолдолд түүнд гэрээний 4.2.4, 4.2.5-т заасан хариуцлагыг хүлээлгэж болно.

4.4. Гишүүн нь гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээний 4.2-т заасан хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран буруутай этгээдийн гишүүний эрхийг үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, хасах зэрэг арга хэмжээ авч болно.

#### ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1 Цахилгаан, сүлжээний дэд бүтэц /үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хамаарах/ болон Биржийн үйл ажиллагаанаас үл хамаарах бусад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцлийн улмаас үүссэн аливаа хохирлыг Бирж хариуцахгүй.

5.2 Энэхүү гэрээг хугацааны эцэст дүгнэж, цаашид сунгах асуудлыг шийдвэрлэнэ. Аль нэг талаас гэрээг дуусгавар болгох санал гаргаагүй бол мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.

5.3 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба 30 хоногийн дотор тодорхой шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг  
төлөөлөн:

“.....” ХХК-ийг  
төлөөлөн:

.....

.....

/...../

/...../

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ:

20..... оны ..... сарын ..... өдрийг хүртэл сунгав.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг  
төлөөлөн:

“.....” ХХК-ийг  
төлөөлөн:

.....

.....

/...../

/...../



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭЭР ӨРГӨДӨЛ  
ГАРГАГЧ КОМПАНИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**



**НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

<b>1 Компанийн ерөнхий мэдээлэл</b>			
1.1	Компанийн нэр		
1.2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар		
1.3	Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан огноо		
1.4	Регистрийн дугаар		
1.5	Компанийн харьяалал		
1.6	Хувьцаат капиталын дүн		
1.7	СЗХ-ны тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Тогтоолын дугаар
	Брокер		
	Дилер		
	Андеррайтер		
	Хөрөнгө оруулалтын зөвлөх		
	Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ		
<b>2 Үйлчилгээний нөхцөл</b>			
2.1	Данс нээх хураамж		
2.2	Арилжааны шимтгэл	Хувьцаа	ЗГ-ийн бонд
			Компанийн бонд
2.3	Харилцагч банк	<i>Нэр</i>	<i>Дансны дугаар</i>
2.4	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны нэр		
2.5	Ажиллах цагийн хуваарь		
<b>3 Хаяг, байршил</b>			
3.1	Ажлын байрны талаарх мэдээлэл	<input type="checkbox"/> Өөрийн	<input type="checkbox"/> Түрээс
3.2	Байршил	Төв: ..... ... Салбар:.....	
3.3	Вэб сайт		
3.4	И-мэйл хаяг		
3.5	Ажлын утас, факс		

4 <i>Үүсгэн байгуулагч</i>				
№	Овог, нэр	Оруулсан хөрөнгийн		Ажил эрхлэлтийн байдал
		Үнийн дүн	Хувь	
5 <i>Төлөөлөн удирдах зөвлөл</i>				
№	Овог, нэр	Албан тушаал	Ажил эрхлэлт	
1				
2				
3				
4				
5				
6				
6 <i>Санхүүгийн үзүүлэлт /..... оны .... сарын .... –ны байдлаар/</i>				
№	Үзүүлэлт	Актив		Пассив
1	Нийт хөрөнгө			
	Эргэлтийн хөрөнгө			
	Эргэлтийн бус хөрөнгө			
2	Өр төлбөр, Эзэмшигчийн өмчийн дүн			
	Өр төлбөр			
	Эзэмшигчийн өмч			
3	Тэнцэл			
4	Аудит хийсэн компани	Нэр:	Хаяг:	
7 <i>Санхүүгийн төлөвлөгөө</i>				
№	Үзүүлэлт	20... он	20... он	20... он
1	Нийт гүйлгээний дүн			
	Хувьцаа			
	Засгийн газрын бонд			
	Компанийн бонд			
2	Нийт орлого			
	1.Брокерийн үйл ажиллагаанаас			
	2. Дилерийн үйл ажиллагаанаас			
	3.Андеррайтерийн үйл ажиллагаанаас			
	4. Бусад орлого			
3	Нийт зардал			
4	Цэвэр ашиг			

8 Ажиллагсдын мэдээлэл /салбарыг оролцуулна/					
№	Ажилтнуудын овог, нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	ҮЦЗЗ-д мэргэжлийн ажил, үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар	
1					
2					
3					
4					
5					
6					
9 Бусад мэдээлэл				Тийм	Үгүй
1	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчиж байсан, сүүлийн 5 жилийн хугацаанд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж, гишүүний эрх нь цуцлагдсан үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх				
2	Өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компани дампуурсан, төлбөрийн чадваргүйд тооцогдож байсан эсэх				
3	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа эсэх				
<i>*“Тийм” хариултын тайлбарыг хавсаргана уу.</i>					
10 Батламж					
<p>“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компани нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн холбогдох журам, заавар, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.</p> <p style="text-align: center;">Тамга                                  Захирал    / Гарын үсэг/</p> <p style="text-align: center;">20... оны ... сарын ... -ний өдөр</p>					

11	<i>Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт</i>	<i>Тайлбар</i>
1	Биржид гишүүнээр элсэхийг хүссэн албан бичиг	Албан бичгээр хүсэлт гаргаж гарын үсэг зуран тамга тэмдгээр баталгаажуулсан байна;
2	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр	Хуулбар, эх хувийн хамт;
3	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	Хуулбар, эх хувийн хамт. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон гэрчилгээний хуулбар, эх хувийн хамт;
4	Компанийн дүрмийн хуулбар	Хуулбар, эх хувийн хамт байна. Дүрмийг Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу боловсруулсан байна;
5	Бизнес төлөвлөгөө	Бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилийн хугацаатай боловсруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Бизнес төлөвлөгөө нь эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь уялдаатай, мэдээлэл нь цаг хугацаандаа, үнэн бодитой, үр дүн нь хэмжигдэхүйц байвал зохино;
6	Санхүүгийн аудитлагдсан тайлан баланс,	Хэрэв шинээр үүсгэн байгуулагдсан компани бол эхлэлтийн баланс, хуулбарын хамт
7	Харилцах дансны баталгаажсан хуулга	Сүүлийн 3 сараас доошгүй хугацааны дансны хуулга;
8	Харилцагч банкны дансны үлдэгдэлтэй тодорхойлолт	СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсны дараа Биржид гишүүнээр элсэх тохиолдолд тодорхойлолт шаардана;
9	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтнуудын татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт	Татварын байгууллагаас тодорхойлолт авах;
10	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын өр төлбөртэй эсэх талаарх ШШГЕГ-ын тодорхойлолт	ШШГЕГ-аас тодорхойлолт авах;
11	Албан тушаалтны мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийн хуулбар, их, дээд сургуулийн дипломын хуулбар, “Гишүүнчлэлийн журам”-ын хавсралтаар баталсан дэлгэрэнгүй анкет, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээний хуулбар;	Үнэмлэхний хуулбарыг, эх хувийн хамт;
12	Тоног төхөөрөмж, програм хангамж, эд хөрөнгийн жагсаалт, журамд заасан	Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмж, програм хангамжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэгийн талаарх мэдээллийг болоод

	шаардлага хангасан эсэхийг тодорхойлох баримт;	тухайн тоног төхөөрөмж, програм хангамжийг худалдаж авсан түрээсэлсэн аль нь болохыг тодорхой бичнэ. Програм хангамжийн зориулалт баганад тухайн програмыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэл, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл, харилцагчийн нэгдсэн сан, захиалга боловсруулах гэх мэт;
13	Түрээсийн гэрээ эсвэл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ	Үл хөдлөх хөрөнгө нь өөрийнх бол гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол түрээсийн гэрээний хуулбар, эх хувийн хамт;
14	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны журмын дагуу дотооддоо мөрдөхөөр гаргасан журам, зааврууд	Ямар зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхээс хамааран тухайн үйл ажиллагаандаа зориулсан дүрэм журмуудыг боловсруулсан байна;
15	Арилжааны төлбөр, тооцоо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар	<p><i>Эдгээр баримт бичгийг СЗХ-ноос зохих тусгай зөвшөөрөл авсны дараа ирүүлнэ;</i></p>
16	Өргөдлийн хураамж төлсөн баримт	
17	Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, СЗХ-ны тогтоолын хуулбар	

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

<b>1 Ерөнхий мэдээлэл</b>							
1.1	Овог		Цээж зураг  3x4 см				
1.2	Нэр						
1.3	Хүйс /сонгох/	Эрэгтэй:					Эмэгтэй:
1.4	Төрсөн он, сар, өдөр						
1.5	Иргэний харьяалал						
1.6	Регистрийн дугаар						
1.7	И-мэйл хаяг:						
1.8	Гэрийн хаяг						
1.9	Холбоо барих утас:	1.	2.				
<b>2 Боловсрол</b>							
2.1	Төгссөн сургуулийн нэр	Хаана	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом, Гэрчилгээний дугаар	
2.2	Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх		Дугаар:	Авсан огноо:	Дуусах огноо:		
<b>Ажлын туршлага /Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ/</b>							
3	Хаана, ямар албан байгууллагад	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан		
<b>Гэр бүлийн байдал</b>							
4	Таны юу болох	Овог нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил		
<b>5 Батламж</b>							

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч  
“.....” компанийн ..... /албан тушаал, хөрөнгө  
оруулагч/ ..... овогтой  
..... нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д ирүүлсэн материалын үнэн  
зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох  
хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны  
зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-  
ийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн  
биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН: \_\_\_\_\_ / Гарын үсэг/ БҮРТГЭЛТЭЙ

ТАНИЛЦСАН: \_\_\_\_\_ /Компанийн захирал/

20 ... оны .... сарын .... өдөр

ХОЁР. А) БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

<b>1 Ерөнхий мэдээлэл</b>						
1.1	Овог			Цээж зураг  3x4 см		
1.2	Нэр					
1.3	Хүйс /сонгох/	Эрэгтэй:	Эмэгтэй:			
1.4	Төрсөн он, сар, өдөр					
1.5	Иргэний харьяалал					
1.6	Регистрийн дугаар					
1.7	И-мэйл хаяг:					
1.8	Гэрийн хаяг					
1.9	Холбоо барих утас:	1.	2.			
<b>2 Боловсрол</b>						
2.1	Төгссөн сургуулийн нэр	Хаана	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом, Гэрчилгээний дугаар
2.2	Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх	Дугаар:		Авсан огноо:	Дуусах огноо:	
<b>Ажлын туршлага /Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ/</b>						
3	Хаана, ямар албан байгууллагад	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан	
<b>Гэр бүлийн байдал</b>						
4	Таны юу болох	Овог нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил	
<b>5 Батламж</b>						



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч  
“.....” компанийн ..... /албан тушаал, хөрөнгө  
оруулагч/ ..... овогтой  
..... нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д ирүүлсэн материалын үнэн  
зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох  
хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны  
зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-  
ийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн  
биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН: \_\_\_\_\_ / Гарын үсэг/ БҮРТГЭЛТЭЙ

ТАНИЛЦСАН: \_\_\_\_\_ /Компанийн захирал/

20 ... оны .... сарын .... өдөр

Б) ГИШҮҮН КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	<i>Компанийн ерөнхий мэдээлэл</i>		
1	Компанийн нэр		
2	Байгуулагдсан огноо		
3	Регистрийн дугаар		
4	Компанийн харьяалал		
5	Үйл ажиллагааны чиглэл		
6	Хувьцаат капиталын дүн		
7	Гишүүн компани дахь эзэмшлийн мэдээлэл	Оруулсан хөрөнгийн үнийн дүн:	Оруулсан хөрөнгийн хувь:
8	Удирдлагын нэр		
9	Компанийн хаяг		
10	Вэб сайт		
11	И-мэйл хаяг		
12	Холбоо барих утас, факс		

---- оОо ----

## АРИЛЖААНЫ СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн компани нь арилжааны системд холбогдохдоо дараах техникийн шаардлагыг хангасан байна:

### Техникийн шаардлага

Millennium Exchange програмын Trader Interface –ийг суулгахад шаардлагатай техникийн шаардлага:

### Холболтын шаардлага

а. Програм хангамжийн түвшин дэх VPN туннел

*Холболтын зурвасын өргөн нь 2 Mbps болон түүнээс доошгүй байх шаардлагатай.*

б. Техник хангамжийн түвшин дэх VPN туннел

*Холболтын зурвасын өргөн нь 3 Mbps болон түүнээс доошгүй байх, IPSec дэмждэг сүлжээний төхөөрөмж байх шаардлагатай.*

с. Шууд холболт

*Холболтын зурвасын өргөн нь 1 Mbps болон түүнээс доошгүй байх, IPSec дэмждэг сүлжээний төхөөрөмж болон холболтын шилэн кабел байх шаардлагатай.*

### Компьютерийн шаардлага

- Intel Dual Core болон түүнээс дээш загварын CPU
- 512 Mb болон түүнээс дээш хэмжээтэй шуурхай санах ой (трэйдэрийн профайлд хадгалах мэдээллийн хэмжээнээс шалтгаалж хувьсана)
- 120 Gb болон түүнээс дээш хэмжээтэй хатуу диск
- 15 инч болон түүнээс дээш хэмжээтэй дэлгэц
- Стандарт гар болон хулгана
- Microsoft Windows XP болон түүнээс хойших үеийн Microsoft–ийн үйлдлийн систем
- Mozilla Firefox 5.0 болон түүнээс хойших хувилбарын интернет хөтөч
- Visual C++ redistribution package

### Ажлын байрны шаардлага:

- Харилцагчийг хүлээн авч үйлчлэх байрыг брокероос бусад ажиллагсдын албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байх;
- Ажилтны тоонд тохирсон шаардлага хангахуйц албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж, компьютер, хэвлэгч, хувилагч, бичлэг хийх боломжтой утас, факсын аппаратаар хангагдсан байх.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

д/д	Үйлчилгээний хөлсний төрөл	Үнийн дүн	Төлбөрийн нөхцөл	Төлөх хугацаа
1	<i>Гишүүнээр элсэх өргөдөл гаргахад төлөх үйлчилгээний хөлс</i>			
1.1.	Гишүүнээр элсэх өргөдлийг хянан шийдвэрлэх үйлчилгээний хөлс	500,000 төгрөг	Буцаан олгогдохгүй	Өргөдөл гаргах үедээ
1.2.	Гишүүнчлэлийн элсэлтийн хөлс	15,000,000 төгрөг	Нэг удаа төлнө	Шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор
2	<i>Гишүүнээр элссэний дараа тогтмол төлөх үйлчилгээний хөлс</i>			
2.1.	Гишүүнчлэлийн хөлс	375 000 төгрөг /улирал тутам/	Брокер, дилерийн тус тусдаа болон хосолсон эрхтэй бол	Улирал бүрийн эхний 10 хоногт багтаан төлнө.
2.2.	Гишүүнчлэлийн хөлс	500 000 төгрөг /улирал тутам/	Брокер, дилер, андеррайтерын эрхтэй бол	
2.3.	Арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс	195 000 төгрөг /улирал тутам/	Арилжааны системд нэвтрэх нэг эрх	